

1

**ХЯНАЛТ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Ц.ЦЭВЭЭНДАРИЙН 2024 ОНЫ  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

100

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/ д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		Эхэлсэн, дууссан хугацаа	
1	2	3	4	5	6	7		
<b>Зорилт 1. "Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах"</b>								
1.	Гадаад худалдааны цахим нэг цонхны системийг бий болгох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	"Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэгт гаалийн байгууллагын төлөөлөл ажиллаж байна.	Эхний хагас жилд: -Цахим нэг цонхны мэдээллийн системийг бий болгох ажлын хэсэгт ажиллаж, холбогдох мэдээллийг хүргүүлсэн байна. Сүүлийн хагас жилд: -Цахим нэг цонхны мэдээллийн системийг бий болгох ажлын хэсэгт ажиллаж, холбогдох мэдээллийг хүргүүлсэн байна.	ЭЗХЯ-ны ТНБД-ын 2023.08.10-ны өдрийн А/138 дугаартай тушаалаар байгуулагдсан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 178 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт заасан Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэгт гаалийн байгууллагын төлөөлөл ажиллаж байна. "Хилийн үйлчилгээг сайжруулах бус нутгийн төсөл"-ийг хэрэгжүүлэгч байгууллага өөрчлөгдсөнтэй холбоотойгоор ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусгасан хугацааг шинэчилж, үйл ажиллагаа нь зохион байгуулгадана. "Хилийн үйлчилгээг сайжруулах бус нутгийн төсөл"-ийн нэгжээс "Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системд оролцогч 19 байгууллагын 40 албан хаагчийг оролцуулсан 2024.03.21, 2024.03.25, 2024.06.20-ны өдөр зохион байгуулагдсан уулзалтуудад оролцсон.	Монгол улсад гадаад худалдааны харилцааг зохицуулах тарифын бус хязгаарлалтын аргаас бүртгэл, зөвшөөрлийн хэлбэрийг хамгийн өргөн хэрэглэдэг бөгөөд улсын хилээр нэвтрүүлэх тодорхой нэрийн бараанд тусгай зөвшөөрөл болон бүртгэл олгох замаар төрөөс хяналт тавьж байна. Иймд гадаад худалдаатай холбоотой дээрх зөвшөөрлийг олгодог байгууллагууд цахим нэг цонх мэдээллийн системийг ашиглаж, олон төрлийн үйлчилгээ, мэдээллийг нэг дор төвлөрүүлсэнээр гаалийн байгууллагын үйл ажиллагааг хялбарчилж, гадаад худалдаанд оролцогч нарт чирэгдэлгүй орчин бурдүүлэхийг зорьж ажиллаж байна.	01.02 12.10	

				<p>-“Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 178 дугаар тогтоолын хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг 2023.06.02-ны өдөр ГЕГ-ын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Дээрх төлөвлөгөөний 2024 оны 1, 3, хагас жилд хэрэгжүүлэхээр тусгагдсан 14 арга хэмжээний биелэлтийг ГЕГ-ын 8 нэгжээс дотоод зурvasaар авч, нэгтгэн 2024 оны 4, 7, 10 дугаар саруудад ө 01/1638, 2769, 4114 дугаартай албан бичгийн хавсралтаар ЭЗХЯ-ны ТНБД-д хүргүүлсэн.</p> <p>Засгийн газрын Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2023 оны 178 дугаар тогтоолын</p> <p>1.1.“Гадаад худалдааны цахим нэг цонх” мэдээллийн системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэх арга хэмжээг ЦХХХЯ-тай хамтран хэрэгжүүлэхийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд ЭЗХ-ийн сайд, Хөрөнгө оруулалт, худалдааны газар, ГЕГ-т даалгасаны дагуу дээрх тогтоолын 1.1, 1.4, 3.1-р заалтын биелэлтийг сар бүр тогтмол гаргаж, ГЕГ-ын ХХ-т хүргүүлэн ажиллаж байна.</p> <p><b>XҮРСЭН ҮР ДҮН:</b></p> <p>1.ГЕГ-ын даргаар 2023.06.02-ны өдөр батлуулсан төлөвлөгөөний 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан 14 арга хэмжээний биелэлтийг ГЕГ-ын 8 нэгжээс дотоод зурvasaар авч, нэгтгэн 2024 оны 4, 7, 10 дугаар саруудад 01/1638, 2769, 4114 дугаартай албан бичгийн хавсралтаар ЭЗХЯ-ны ТНБД-д хүргүүлсэн.</p> <p>2.Сангийн яаманд сар бүр хүргүүлэх Засгийн газрын 178 дугаар тогтоолын 1.1, 1.4, 3.1 дүгээр заалтын биелэлтийг сар бүр тогтмол гаргаж, дараа сарын 01-ний өдрийн дотор ГЕГ-ын Хуулийн хэлтэст хүргүүлж ажилласан.</p> <p>3.Гаалийн бүрдүүлэлтийн автоматжуулсан CEPS, CAIS системд нэмэлт хөгжүүлэлт хийж, эм, эмнэлгийн хэрэгслийн импортын мэдүүлгийг E-mongolia болон эмийн бүртгэл, мэдээллийн Licensed системээс цахимаар татах, гаалийн бүрдүүлэлт хийдэг болгосон.</p> <p>4.Онцгой албан татвартай баараны хяналтыг сайжруулах зорилгоор тусгай зөвшөөрөл, онцгой албан татварын</p>	
--	--	--	--	---	--

					tэмдэгтэй холбоотой мэдээллийг ХХААХҮЯ, Татварын Ерөнхий газартай солилцох системын хөгжүүлэлтийг хийж байна. Үүний үр дүнд гадаад худалдаанд оролцогч нар согтууруулах ундааны тусгай зөвшөөрөл, эм, эмнэлгийн хэрэгслийн импортын мэдүүлгийг цаасаар гаалийн байгууллагад гаргаж өгөх шаардлагагүй болж, бурдүүлэх бичиг баримтын тоо багасна. 5.Озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан, ашигласан тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах зөвшөөрлийг цахимжуулан, CAIS-т холбож, мэдээлэл солилцох системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд БОУАӨЯ-ны ОҮА-тай хамтран ажиллаж байна.	
2	Автозамын хилийн боомтуудын хилээр нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, дэд бүтцийг өргөтгөн шинэчлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Эхний хагас жилд: ГХБ-д ухаалаг гарцын тоног төхөөрөмж суурилуулж, хяналтыг сайжруулах арга хэмжээ зохион байгуулсан байна. Сүүлийн хагас жилд: Алтанбулаг, Баянхошуу, Гашуунсухайт боомтуудын бүтээн байгуулалттай уялдуулан ухаалаг гарцын системийг нэвтрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байна.	Гашуунсухайт боомтын бүтээн байгуулалттай холбоотойгоор гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг суурилуулах ажил дууссантай холбоотойгоор шалгаж хүлээн авах зорилготой ажлын хэсэг 2024 оны 9 дүгээр сарын 08 – 14-ны өдрүүдэд Гаалийн ерөнхий газрын даргын удирдамжаар ажлын хэсэг ажиллан Зорчигч, ердийн ачаа тээврийн терминалд суурилагдсан 20 тоног төхөөрөмж, Уул уурхайн бүтээгдэхүүний эрдэс бүтээгдэхүүний экспортын терминалд суурилагдсан 33ш тоног төхөөрөмжийг туршин шалгаж гүйцэтгэгчид 14 гүйцэтгэх үүрэг даалгавартайгаар, ГСГГ-аас хяналт тавьж гүйцэтгэлийг бүрэн хангуулах, бүрэн хангагдсаны дараа хүлээн авах саналтайгаар ГЕГ-ын даргын 2024.03.28-ны өдрийн А/191 тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хуралдаанд танилцуулсан. Гүйцэтгэгчээс дээрх үүргийг богино хугацаанд бүрэн хэрэгжүүлэн ГСГГ -ын албан хаагчдад холбогдох сургалтыг зохион байгуулан ажилласнаар одоо бүрэн ажиллагаанд орон гаалийн хяналт, шалгалтын үйл ажиллагаанд ашиглагдаж байна.  Тус боомтод суурилагдсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжүүд бүрэн ажиллах боломжтой ч БНХАУ -ын татан авалт болон хил хамгаалах байгууллагын жолоочийн /бичиг баримтын/ хяналттай уялдуулан хяналт шалгалтын хэсгийн 3-4 гарц ажиллаж байна.	01.02 12.10

					Ухаалаг гарцын тоног төхөөрөмжүүдийг боомтын бүтээн байгуулалттай уялдуулан Замын-Үүд, Гашуунсухайт боомтуудад бүрэн, Шивээхүрэн, Хангийн боомтуудад одоогийн нөхцөл байдалтай уялдуулан холбогдох байршилуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар суурилуулаад байгаа бол Алтанбулаг, Боршоо боомтуудын хувьд Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр суурилуулахаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагын шийдвэрээр тендер сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.  Замын-Үүд болон Гашуунсухайт, Шивээхүрэн боомтод суурилагдсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийн ашиглалтын өнөөгийн нөхцөл шаардлагад тулгуурлан Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/275 тушаалаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”-ын 1.4-д заасны дагуу “Гаалийн хяналтад ухаалаг гарцын тоног төхөөрөмж ашиглах заавар” -ын төслийг 2023 оны 10 дугаар сард боловсруулан ГЕГ-ийн бүтцийн нэгжүүд, гаалийн газар хороодод хүргүүлэн санал авч өөрчлөлтийг тусган 2024 оны 04 сард дахин санал авч 2024 оны 9 дүгээр сард Гаалийн Ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн зааврыг гаалийн хяналт, шалгалтын үйл ажиллагаанд ашиглах, Эрсдлийн удирдлагын хэлтэс тус зааврын дагуу ухаалаг гарцын системийг иж бүрэн ажиллуулахад шаардлагатай шалгуур үзүүлэлтийг боловсруулж системийн ажиллах нөхцөл боломжийг бурдүүлэхийг МЗХ-ны 2024 оны 09 дүгээр сарын 19-ны өдрийн 07/02 дугаартай тэмдэглэл шийдвэрлэн Гаалийн Ерөнхий газрын даргын 2024 оны А/532 дугаар тушаалын хавсралтаар тус зааврыг баталсанаар хилийн боомт, гаалийн хяналтын бүсэд ухаалаг гарцын тоног төхөөрөмжийн тусламжтайгаар бараа, тээврийн хэрэгслийн бурдүүлэлтэд хяналт тавих эрх зүйн орчин бүрдээд байна.	
3	Автозамын хилийн боомтод сууриуулса	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		Эхний хагас жилд: -Хил хамгаалах ерөнхий газартай хамтарсан ажлын	-Хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн зөрүү гаргахгүй, мөн хилийн хяналтын байгууллагуудын давхардсан шалгалтыг багасгаж, хяналтаа сайжруулахын тулд автозамын хилийн боомтууд дээр гаалийн	01.02 12.10

	н ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг ашиглан хил хамгаалах байгууллага тай хамтран ажиллаж, хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг нэгтгэнэ		хэсэг байгуулж, солилцох мэдээллийг тохирсон байна. Сүүлийн хагас жилд: -Ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг ашиглан хил хамгаалах байгууллагатай хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг ижилсгэсэн байна.	байгууллага болон хил хамгаалах байгууллагын тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын системийг уялдуулахаар хамтран ажиллаж байна. Дээрх ажлыг хэрэгжүүлэхээр ХХЕГ-ын Холбоо, мэдээллийн технологийн аюулгүй байдлын газартай хамтарсан ажлын хэсэг байгуулгадаж, гаалийн байгууллагаас: 1.тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг өгөгдөл дамжуулах байдлаар илгээж, танай байгууллагаас тухайн тээврийн хэрэгслийн жолооч, зорчигч нарын тодорхой мэдээллийг хүлээн авах; 2.хилээр түр хугацаагаар тээврийн хэрэгсэл оруулсан гадаадын иргэн, харьяалалгүй хүн хилээр гарах үед нь түр хугацаагаар оруулсан тээврийн хэрэгслийн бүртгэлийг шалгаж, нягтлах зэрэг ажлуудыг хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласан. Үүний үр дүнд улсын хилээр орох болон гарах талд хил нэвтэрсэн авто тээврийн хэрэгслийн дугаараар ХХЕГ-аас сервисээр мэдээлэл татах боломжийг бүрдүүлсэн. Тус мэдээлэлд жолооч, зорчигчийн овог, нэр, регистрийн дугаар, гадаад паспортын дугаар, төрсөн он сар өдрөөр Хил хамгаалах ерөнхий газрын баталгаажуулсан мэдээллийг хүлээн авч гаалийн хяналт шалгалтад ашиглах, эрсдэл тооцох боломжтой болгосон. Мөн цаашид төмөр зам, агаарын тээврийн хэрэгслээр хил нэвтэрсэн зорчигчийн мэдээллийг Хил хамгаалах байгууллагын баталгаажуулсан мэдээллийг авахаар ажиллаж байна. <b>Хүрсэн үр дүн:</b> 1.ХХЕГ-ын Холбоо, мэдээллийн технологийн аюулгүй байдлын газартай хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллаж, хамтарсан уулзалт зохион байгуулан, сервисын мэдээллээ дахин шинэчилж хүргүүлсэн. 2.Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх ХУН төслийн хүрээнд программ хийлгэж, автозамын хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээлэл солилцох туршилтыг 2024 оны 11 дүгээр сард Замын-Үүд боомтод хийж, нэвтрүүлсэн.	
4	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Эхний хагас жилд: -Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрхэн хэрэгжүүлэх талаар	Нэгжийн чиг үргийн давхардал, хийдэл үүсгэхгүйгээр үр дүнтэй зохион байгуулахад учирч болзошгүй эрсдэлийг таньж, тогтоон түүнийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлж, дараах чиглэлээр судалгаа хийсэн. Үүнд:	01.02 12.10

				<p>ЭҮХ-ээс зөвлөгөө, чиглэл авах ажлыг зохион байгуулсан байна.</p> <p>Сүүлийн хагас жилд:</p> <p>-ЭҮХ-ээс авсан чиглэлийн дагуу нэгжийн эрсдэлийг таньж тогтоох, ангилж санд бүртгэх арга хэмжээ зохион байгуулсан байна.</p>	<p>1.Хүний нөөц, бүтэц, зохион байгуулалттай холбоотой эрсдэл тооцох;</p> <p>2.Нэгжийн үндсэн чиг үүрэг, чиг үүргийн харьцуулалт;</p> <p>3.Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй ажлаас гадуур болон цаг үеийн шинжтэй гүйцэтгэсэн ажил;</p> <p>4.Нэг албан хаагчид ногдох ажлын ачаалалтай холбоотойгоор ажлын цаг ашиглалт, илүү цаг болон бусад дотоод ажил;</p> <p>5.Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласан байдал.</p> <p>Тус нэгжийн албан хаагч нар олон чиглэл хариуцаж, чиглэл тус бүрийг нарийвчлан судлах шаардлагатай байдаг. Иймд чиг үүргийг хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг дараах байдлаар тооцоолж,</p> <ul style="list-style-type: none"> <li>- эрсдэлийн зэрэглэл өндөр үнэлэгдсэн тохиолдолд түүнийг бууруулах арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх;</li> <li>-дунд түвшинд үнэлэгдсэн тохиолдолд байнга хяналт тавьж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;</li> <li>-бага түвшинд үнэлэгдсэн тохиолдолд эрсдэлийг тасралтгүйгээр хянан үзэхээр ажиллаж байна. Мөн доор дурдсан давуу болон сул тал, хүндрэлтэй асуудлуудыг таньж, тогтоон хянаж ажиллаж байна.</li> </ul> <p>Давуу тал:</p> <ol style="list-style-type: none"> <li>1.Багаар ажиллаж, ажиллагсад хоорондын ажил үүргийг орлон гүйцэтгэх чадвартай албан хаагч нар ажилладаг;</li> <li>2.Албан тушаалын чиг үүргийн хүрээнд авилга, ашиг сонирхлоос ангид байж, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигладаггүй;</li> <li>3. Гаалийн байгууллагын бодлого, чиглэлийг тодорхойлоход дэмжлэг болох мөн чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, танилцуулгыг цаг тухай бүр ажил, амралтын цаг харгалзахгүйгээр гаргаж удирдлагад хүргүүлдэг;</li> <li>4. Ажлын ачаалал даах чадвартай. Энэ нь албан хаагч нарын "Ажлын зураг авалтын хуудас"-аас харагдана;</li> <li>5. Ажлын бус цагаар, амралтын өдрүүдээр яаралтай мэдээ, танилцуулга бэлтгэх шаардлага тулгарахад шалтгаан тоочихгүйгээр тухай бүр ажиллаж чаддаг;</li> <li>6. Шаардлага тохиолдсон үед эсхүл хэн нэг нь ачаалал ихтэй байх үед өөрийн чадахаар нэг нэгэндээ туслаж, ачааллаас нь хуваалцдаг.</li> </ol>	
--	--	--	--	--	--	--

				<p>Сул тал /хүндрэлтэй асуудал/:</p> <p>1.Шаардлагатай мэдээ тайлан богино хугацаанд гаргахад эрхийн хязгаарлалтай байдаг. Тухайлбал сар бүр Сангийн яаманд гаргаж хүргүүлдэг Гэрээ бүртгэлийн нэгдсэн системээс гаргах тоон мэдээллийг авах эрх байхгүй учраас СМТТ УТҮГ-т хандаж, тодорхойгүй хугацаагаар хүлээдэг;</p> <p>2. Квот, ГИТ, гаалийн мэдүүлгийг татгалзах, хүчингүй төлөвт шилжүүлэх, горимд байршуулах хугацаа сунгах зэрэг нэгжийн чиг үүргийн дагуу зөвхөн тухайн асуудлыг хариуцсан ГУБ нарт байх шаардлагатай эрхүүдийг өөр бусад албан хаагч нар ашиглах боломжтой байгаа эсэхийг хянах боломжгүй байдаг;</p> <p>3. CAIS-т нэвтрэхдээ тоон гарын үсэг ашиглахгүй байгаа нь нууцлал, аюулгүй байдлыг хангахгүй байна;</p> <p>4. CAIS-аас шаардлагатай мэдээг татаж чаддаггүй, гар ажиллагаа ихтэй;</p> <p>5. Сангийн яамнаас мэдээ, биелэлтийг хугацааг нь тулгаж, 2 цагийн дотор ирүүл эсчүүл 10:10 цагт өгөөд 13:30 цагаас өмнө ирүүл гэх мэтээр шаарддаг.</p> <p><b>ХҮРСЭН ҮР ДҮН:</b></p> <p>1.ХБГ-ын гүйцэтгэлд нөлөөлөх эрсдэлийг. -Бүтэц зохион байгуулалт; -Үйл ажиллагаа; -Хууль тогтоомж; -Мэдээллийн технологи гэсэн 4 чиглэлээр тодорхойлж гаргасан.</p> <p>2.Хяналт, бүрдүүлэлтийн газрын үйл ажиллагааг тогтвортой зохион байгуулахын тулд дээрх эрсдэл үүсгэж байгаа хүчин зүйл бүртэй холбоотой эрсдэл гарах магадлал, үр дагаврыг 3x3 матрицын тусламжтай гаргасан.</p> <p>3. Нийт 4 хүчин зүйлийн хүрээнд тодорхойлсон 8 эрсдэлээс 5 нь хамгийн өндөр, 3 нь бага эрсдэлийн зэрэглэлтэй гэж үнэлэгдсэн тул хүчин зүйл тус бүрийн хүрээнд тодорхойлсон эрсдэлийг бууруулах арга хэмжээ тус бүрийг хариуцах, нэгжийн тодорхойлсон.</p> <p>1. Эрсдлийн удирдлагын хэлтсээс гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаатай холбоотойгоор эрсдлийн шалгууруудын өөрчлөлт, эрсдлийн профайл зэрэг үндсэн үзүүлэлтүүдэд оруулах өөрчлөлтийг Хяналт,</p>	
--	--	--	--	--	--

				<p>Бүрдүүлэлтийн Газрын дарга хянаж, дэд дарга батлах хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, ГЕГ-ын Мэргэжлийн зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанд танилцуулж батлуулсан.</p> <p>Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны уг шийдвэрийг үндэслэн Эрсдлийн удирдлагын хэлтсээс 2023 онд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Заавал шалгах шалгуур нэмэх – 85</li> <li>- Заавал шалгах шалгуураас хасах – 6</li> <li>- Зөвшөөрөгдсөн шалгуурт нэмэх -375</li> <li>- Зөвшөөрөгдсөн шалгуураас хасах -32</li> <li>- Өндөр эрсдлийн шалгуур нэмэх – 28</li> <li>- Үл хамаарах шалгуурт өөрчлөлт оруулах -60</li> <li>- Санамсаргүй сонголтын шалгуур өөрчлөх -7 нийт 593 шалгуурын өөрчлөлтийн хяналтыг 55 хяналтын хуудсаар,</li> </ul> <p>2024 оны эхний хагас жилд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Эрсдлийн профайл -9</li> <li>- Заавал шалгах шалгуур нэмэх – 31</li> <li>- Заавал шалгах шалгуураас хасах – 2</li> <li>- Зөвшөөрөгдсөн шалгуурт нэмэх -31</li> <li>- Зөвшөөрөгдсөн шалгуураас хасах -6</li> <li>- Өндөр эрсдлийн шалгуур хасах – 1</li> <li>- Үл хамаарах шалгуураас хасах -1</li> <li>- Өндөр эрсдлийн шалгуур, Үл хамаарах шалгуурт өөрчлөлт оруулах – 23 нийт 95 хяналтын хуудсаар,</li> </ul> <p>483 шалгуур үзүүлэлт хянуулах хүсэлт ирүүлснийг Хяналт, бүрдүүлэлтийн газрын дарга хянан баталгаажуулж ажилласан байна.</p> <p>Дээрх шалгуурыг боловсруулсан, Эрсдэлийн удирдлагын программд оруулсан үр дүнд бичиг баримтын болон бараанд хийх шалгалтаас нийт мэдүүлгийн 63.1%-ийг чөлөөлсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 3.5%-иар өссөн ээрэг статистик үзүүлэлттэй байна.</p> <p>2. Хилийн хорио цээрийн хяналт шалгалтад эрсдэл тооцох, гаалийн автоматжуулсан системтэй холбох:</p>	
--	--	--	--	---	--

				<p>“Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Монгол Улсын Шадар сайдын Ажлын алба Интерактив ХХК-ийн хооронд байгуулсан CS3 дугаартай “Хилийн хяналт удирдлага”-ын зөвлөх үйлчилгээний гэрээг шинэчилж гаалийн хяналт, шалгалтыг хилийн хорио цээрийн хяналттай уялдуулах, тухайн үйл ажиллагаанд эрсдэлийг тооцох, “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын хяналтын удирдлагын систем”-ийг гаалийн автоматжуулсан мэдээллийн системтэй холбох ажилд чиг үүргийн хүрээнд ХБГ, ЭУХ болон ХЦХ хамтран оролцон ажиллаж байна.</p> <p>Төслийн хүрээнд хийгдэх системийн бодлогын даалгаварт бараа, тээврийн хэрэгсэл хилээр орж ирэх үеэс эзэнд олгох, экспортын барааг гүний гаалийн хяналтын бүсэд орсон үеэс хилээр гарах хүртэл гаалийн хяналт шалгалтын үе шат бүрээр хийгдэх процесс ажиллагааг тодорхойлон санаалаа тусган ажилласан. Тус тесел нь шадар сайдын ажлын албанаас хэрэгжүүлж байгаа бөгөөд одоогоор төслийн төсөвтэй холбоотой тодорхойгүй байдал үүссэн нэхцөл байдалтай байна.</p> <p>Уг ажлын хүрээнд ХЦХ -ээс ирүүлсэн Хилийн хорио цээрийн өндөр эрсдэлтэй, заавал шалгах барааны мэдээллийг хүлээн авч хорио цээрийн хяналтад хамрагдах экспортын 2240 нэрийн бараанд БТКУС-ын ангиллаар дүн шинжилгээ хийж, 960 нэрийн барааг эрсдэлийн “заавал” шалгуураар хянах зохицуулалтыг бий болгосноор хорио цээрийн чиглэлээр экспортын хяналтад хамрагдах бараа 57 хувиар буурсан байна.</p> <p>3. Боомтын сэргэлт, гаалийн шинэчлэлийн хүрээнд хилийн боомтуудад суурилагдсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг сайжруулах:</p> <p>Гаалийн Ерөнхий газрын даргын 2019 оны А/275 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам” -д ухаалаг гарц суурилуулсан хилийн боомтод тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтад тусгайлсан заавар мөрдөхөөр заасны дагуу Хяналт, бүрдүүлэлтийн газраас тухайн зааврын төслийг боловсруулан 2024 оны 09 дүгээр сард Гаалийн ерөнхий газрын мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд танилцуулсан.</p>	
--	--	--	--	---	--

					<p>Уг хуралдааны тэмдэглэлийн 2 дахь хэсэгт Эрсдлийн удирдлагын хэлтэс тус зааврын дагуу ухаалаг гарцын системийг иж бүрэн ажиллуулахад шаардлагатай шалгуур үзүүлэлтийг боловсруулж системийн ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэхийг даалгасан. Уг ажлын хэрэгжилтийн хүрээнд ЭУХ -т зааврын эцсийн хувилбар, МЗХ -ны шийдвэрийг хүргүүлсэн.</p> <p>Тус хэлтсээс тээврийн хэрэгсэл улсын хилээр нэвтрэх үед жолооч болон тээврийн хэрэгсэлтэй холбоотойгоор гаалийн хяналт шалгалтад хамруулах, чөлөөлөх эрсдлийн шалгуурыг боловсруулах ажлын хүрээнд хилийн боомтуудын хилийн хөдөлгөөн, зөрчлийн нөхцөл байдал болон бусад шаардлагатай мэдээлэл цуглуулах судалгааны ажлууд хийгдэж програм хангамжийг Санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ-тай хамtran боловсруулан ажиллаж байна.</p>		
5	IRU олон улсын байгууллага болон Монголын авто тээвэрчдын нэгдсэн холбоо (НАРТАМ) – той хамtran TIR-EPD, e-TIR системүүдтэй мэдээллийг цахимаар солилцох	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		<p>Эхний хагас жилд: ОУАТХ-ны программ хангамжийн багтай цахимаар холбогдох 2 талын хугацаа нь дууссан эрхийг нээлгэсэн байна.</p> <p>Сүүлийн хагас жилд: IRU олон улсын байгууллага болон Монголын авто тээвэрчдийн нэгдсэн холбоо (НАРТАМ) –той хамtran TIR-EPD, e-TIR системүүдтэй мэдээллийг цахимаар солилцох программыг туршиж, нэвтрүүлсэн байна.</p>	<p>Олон Улсын автотээврийн холбооны програм хангамжийн багтай Монгол Улсын гаалийн байгууллагын CAIS системд ТИР-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг уялдуулж, холбох ажлыг 2021 оны 9 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлсэн. IRU-ийн зөвлөх Вахтанг Заандиятай 2024.05.22-ны өдөр харилцан санал солилцож, тохиролцсоны дагуу 2024.10.24-ний өдрөөс эхлэн IRU-тай TIR-EPD-ийн 6 элементийг туршиж, дараа нь CAIS-т нарийн үйлдлүүдийг хийсэн.</p> <p>ГЕГ-ын дэргэдэх МТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ганзоригоор ахлуулсан ажлын хэсгийн хамт 2024.11.10 - 2024.11.15-ны өдрүүдэд Замын-Үүд боомтод томилолтоор ажиллаж CAIS-т ТИР-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг холбох туршилтыг хийж, амжилттай нэвтрүүлсэн. Дээрх ажилтай холбоотойгоор МТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ганзориг 2024.11.11-ний өдөр CAIS-т ТИР-ын урьдчилсан цахим мэдүүлгийн систем TIR-EPD-ийг бүртгэх сургалтыг ЗҮГГ-т зохион байгуулж, ЗҮГГ-ын 15 албан хаагчийг танхимаар, УБГГ, СЭГГ, БӨГГ, ХОГГ, ДАГГ-ын 98 албан хаагчийг цахимаар оролцуулсан.</p> <p>ГЕГ-ын дарга Р.Отгонжаргал Олон улсын автотээврийн холбооны ТИР болон дамжин өнгөрөх тээврийн хэлтсийн ахлах зөвлөх Вахтанг Заандиятай 2024.11.18-ны өдөр ГЕГ-ын 1 дүгээр давхарын хурлын танхимд хийсэн</p>	01.02 12.10	

					уулзалтад оролцож, CAIS системд ТИР-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг холбож, нэвтрүүлсэн ажлын явцыг дүгнэсэн. Цаашид Замын-Үүдээс бусад боомтоор ТИР карней бүхий бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлсэн мэдээг CAIS-т хүлээн авах хугацааг тодруулах, ойлголтын зөрүүг арилгах зорилгоор ГЕГ-ын ХБГ, ГЕГ-ын дэргэдэх МТГ-ын албан хаагч нар IRU-ын програм хангамжийн багийнхантай хамтарч ажиллаж байна.		
6	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Чиглэл хариуцсан ГУБ нарын бодлогын бичиг баримт, эрх зүйн актын биелэлт болон хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд зохион байгуулсан арга хэмжээний биелэлтийг хянаж, хариуцсан нэгжид хугацаанд нь хүргүүлнэ.	XУРСЭН ҮР ДҮН: 1.Монгол Улсын гаалийн байгууллагын CAIS системд 2024.11.24-ний өдөр ТИР-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг холбож, нэвтрүүлсэн. 2.CAIS-т TIR-ын урьдчилсан цахим мэдүүлгийн систем TIR-EPD-ийг бүртгэх сургалтыг 2024.11.11-ний өдөр ГЕГ-ын дэргэдэх МТГ-ын албан хаагч настай хамтран ЗҮГГ-т зохион байгуулж, ЗҮГГ-ын 15 албан хаагчийг танхимаар, УБГГ, СЭГГ, БӨГГ, ХОГГ, ДАГГ-ын 98 албан хаагчийг цахимаар оролцуулсан. 4.IRU-ийн ТИР болон транзит хариуцсан ахлах зөвлөх Вахтанг Заандиятай хамтран TIR-EPD холболтын гүйцэтгэлийн үнэлгээ, CAIS дахь ТИР карней статусыг шалгах, EGIS шалгалтыг хэрхэн хийсэн тухай, EPD028/EPD016 мессежийг автоматжуулахтай холбоотой техникийн асуудлуудыг хамтран хянасан. Дараах бодлогын бичиг баримт, эрх зүйн актын биелэлтийг гаргаж, ГЕГ-ын ХХ-т сар бүр тогтмол хүргүүлэхэд холбогдо шаардлагатай мэдээллийг гарган өгч ажиллаж байна. Үүнд: УИХ-ЫН ТОГТООЛ: -2023 оны Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2023 оны 06; ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ: -2023.05.03-ны 159 дүгээр тогтоолын 1; -2023.05.17-ны 178 дугаар тогтоолын 1; -2024.04.10-ны 150 дугаар тогтоолын 4; ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭМДЭГЛЭЛ: -2022.05.11-ний 28-р тэмдэглэлийн XYI.4; -2023.10.04-ний 40-р тэмдэглэлийн 1, 2; ЗАСГИЙН ГАЗРЫН АЛБАН ДААЛГАВАР: -2022.12.16-ны 10-р даалгаврын 2;	01.02 12.10	

7	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		<p>Эхний хагас жилд: Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэсэн байна. Сүүлийн хагас жилд: Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэсэн байна.</p>	<p>ГЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Ханги дахь гаалийн газрын даргын ажлыг хүлээнцэхээр 2024.03.31-2024.04.03-нд томилолтоор ажилласан.</p> <p>ГЕГ-ын даргын 2024.04.10-ны өдөр баталсан удирдамжийн дагуу НҮБ-ын Хар тамхи, гэмт хэргийн албанаас /UNODC/ хэрэгжүүлдэг чингэлэг хяналтын хөтөлбөртэй холбоотой асуудлаар Tomas Dixon, Hugo Bartoly нартай 2024.04.13-2024.04.15-нд ЗҮГГ-т томилолтоор ажилласан.</p> <p>ГЕГ-ын дэд даргын 2024.06.11-ний өдөр баталсан удирдамжийн дагуу Гашуунсухайт боомтын зорчигч, нүүрсний хэсэгт суурилуулах ухаалаг гарц системийн иж бүрдэл тоног төхөөрөмжийг нийлүүлэх, угсрах, суурилуулах гэрээний хэрэгжилтийг шалгахаар 2024.06.12-2024.06.19-ний өдрүүдэд томилолтоор ажилласан.</p> <p>ГЕГ-ын даргын 2024.06.18-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Цогцэций суманд байрлах ЭТТ нүүрс баяжуулах үйлдвэрийн нээлтийн арга хэмжээнд оролцох, ГХБ-ээр тогтоох боломжийг судлах, ГСГГ-ын үйл ажиллагаатай танилцаж, ГХБ-ийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, ДОГГ-ын эд хөрөнгөд тооллого хийх, Чойболсан ОУНБ-тай танилцахаар 2024.06.19-2024.06.23-ны өдрүүдэд дэд даргын хамт ГСГГ, ДОГГ-т томилолтоор ажилласан.</p> <p>ГЕГ-ын дэд даргын 2024.07.30-ны өдөр баталсан удирдамжийн дагуу ГУБ Э.Одбаяр Булган, Боршоо боомтод 2024.08.02-12-ны өдрүүдэд ажиллаж, шинээр суурилуулсан Булган-ИСБА 008 шаардлага хангасан эсэхийг ГУБ Э.Одбаяр, СХОГ, БХ, ШУТ-ийн албан хаагч нарын хамт шалгасан.</p> <p>ГЕГ-ын даргын 2024.08.13-ны өдөр баталсан удирдамжийн дагуу СХОГ, ШУТ-ыг ГУБ нарын хамт 2024.08.15-18-нд Ханги боомтод ажиллаж, RFID-байршуулах цэгийг тогтоосон.</p>	01.02 12.10	
---	--------------------------	-------------------------	--	--	--	----------------	--

				<p>ГЕГ-ын даргын 2024.09.04-ний өдөр баталсан удирдамжийн дагуу Замын-Үүд боомтын ачаалал, СШГГ-ын хяналтад үйл ажиллагаа явуулж байгаа ГХБ-тэй танилцах, зарим нэр төрлийн барааг хилээс гүн рүү татах боломжийг судлах зорилгоор ГЕГ-ын дэд дарга Г.Энхтайвантай хамт томилолтоор ажилласан.</p> <p>ГЕГ-ын даргын 2024.09.05-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Гашуунсухайт боомтод сууринуулсан ухаалаг гарцын иж бүрдэл тоног төхөөрөмжийг хүлээн авах ажлаар 2024.09.08-2024.09.14-ний өдрийг дуустал хугацаанд тус боомтод томилолтоор ажилласан.</p> <p>ГЕГ-ын даргын 2024.10.08-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Алтанбулаг боомт дахь ачааны, суудлын тээврийн хэрэгсэл шалгах рентгены засварыг гүйцэтгэх гэрээ байгуулсан Масс теч ХХК-ийн гүйцэтгэлийг шалгахаар тус боомтод 2024.10.09-11-ний өдрүүдэд СХОГ, БХ-ийн албан хаагч нарын хамт томилолтоор ажилласан.</p> <p>ГЕГ-ын даргын 2024.10.08-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Алтанбулаг боомт дахь ачааны, суудлын тээврийн хэрэгсэл шалгах рентгены засварыг гүйцэтгэх гэрээ байгуулсан Масс теч ХХК-ийн гүйцэтгэлийг шалгахаар тус боомтод 2024.10.09-11-ний өдрүүдэд СХОГ, БХ-ийн албан хаагч нарын хамт томилолтоор ажилласан.</p> <p>ГЕГ-ын даргын 2024.10.10-ны өдрийн A552 дугаартай тушаалын дагуу Хөх хотноо 2024.10.15-2024.10.17-ны өдрүүдэд ГХЯ, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын Засгийн хооронд зохион байгуулагдах ЭКСПО 6-р ажлын хэсгийн уулзалтад оролцсон.</p> <p>ГЕГ-ын даргын 2024.11.08-ны өдөр баталсан удирдамжийн дагуу ЗҮГГ-т CAIS, smartgate.ecustoms.mn, ухаалаг гарц хоорондын мэдээлэл солилцож буй байдлыг хянаж, дүгнэлт гаргах, алдааг илрүүлж, арилгуулах ажлаар 2024.11.13-2024.11.19-нийг дуустал хугацаанд Замын-Үүд боомтод томилолтоор ажилласан.</p>	
--	--	--	--	---	--

					MU-ын Сайд, БСҮХ-ны дарга Б.Тулга Гашуунсухайт боомтод ажиллахтай холбогдуулан ГЕГ-ын ЗҮГ-ын даргын 2024.11.20-ны өдөр баталсан удирдамжийн дагуу ГСГГ-т 2024.11.22-2024.11.25-ны өдрийг дуустал хугацаанд ГЕГ-ын дарга, дэд дарга, ТОГ, БХ, ГТЛ-ийн дарга нарын хамт ажилласан.  ГЕГ-ын даргын 2024.11.25-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Ханги боомтод сууринуулсан ухаалаг гарцын системийн иж бүрдэл тоног төхөөрөмжийг хүлээн авахаар ШХТ, СХОГ-ын албан хаагч нарын хамт 2024.11.27-2024.12.01-ний өдрийг дуустал хугацаанд тус боомтод томилотоор ажилласан.	
8	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	-Ажлын өдрийн өглөө орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлж, томилот, уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох, томилотоор ажиллах, ээлжийн амралт, чөлөө авах хүсэлтийг CERP-д тухай бүр оруулан, илгээн.	2024.06.05-ны байдлаар ажлын өдрийн өглөө орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлсэн. 2024 оны эхний хагас жилд: -томилотоор ажиллах 4; -уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох 8; -бусад 2 буюу нийт 14 хүсэлтийг тус тус CERP-д тухай бүр оруулан, илгээж, хянуулсан.	01.02 12.10
Зорилт 4:"Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх"						
9	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт гүйцэтгэлээр	ГЕГ-ын даргын 2019 оны А/275 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан хяналтын нийтлэг журмын 1.4-	Ухаалаг гарцын тоног төхөөрөмж ашиглах зааврын төсөл боловсруулна.	Гаалийн Ерөнхий газрын даргын 2019 оны А/275 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам" -д ухаалаг гарц сууринуулсан хилийн боомтод тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтад тусгайлсан заавар мөрдөхөөр заасны дагуу Хяналт, бүрдүүлэлтийн газраас тухайн зааврын төслийг боловсруулан 2024 оны 09 дүгээр сард Гаалийн ерөнхий газрын мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 10	01.02 12.10

			т "Ухаалаг гарц нэвтрүүлсэн хилийн боомтуудад хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгслийг буртгэхэд тусгайлан тогтоосон заавар мөрдөнө" гэж заасан боловч заавар батлагдаагүй байсан.		дугаар сарын 02 -ны өдрийн A/532 дугаар тушаалын хавсралтаар "Гаалийн хяналт, шалгалтад ухаалаг гарцын тоног төхөөрөмж ашиглах заавар"-ыг батлуулсан.		
--	--	--	---	--	---	--	--

**Хоёр: Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	Танилцуулга бэлтгэх	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Танилцуулга бэлтгэх	Сангийн сайдаас ГЕГ-ын удирдлагуудад өгсөн үргийн дагуу Замын-Үүд боомтоор оруулсан олон хүлээн авагчтай бараа болон улс хоорондын шуудан илгээмжийг Улаанбаатар хотод гаалийн хяналтад хүлээн авч хяналт, бурдүүлэлт хийж боомт дээрх төвлөрлийг бууруулах танилцуулгыг 2024.04.17-19-ний өдрүүдэд бэлтгэсэн.	04.17 04.19	100
2	Хуралд оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	ХБЗ-аас зохион байгуулах уулзалтад оролцох	Хилийн Замын-Үүд боомтын цагийн горимд өөрчлөлт оруулах, боомтын бэлэн байдлыг хангаж, бэлтгэл ажлыг эхлүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлтийн хурал 2024.01.19-ний өдрийн Баасан гаригийн 11:00 цагаас Хилийн боомтын захиргааны хурлын танхимд зохион байгуулагдсан дүгнэлтийн хуралд оролцсон.	01.19 01.19	100
3	Уулзалтад оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	УБТЗ ХНН-ээс зохион байгуулах уулзалтад оролцох	УБТЗ-ын гаалийн хэлтэсээс 2024.02.06-ны өдрийн 10:00-12:00 цагт зохион байгуулсан төмөр замын боомтоор нэвтрэх барааны	02.06 02.06	100

					дагалдах бичиг баримтыг цахимаар солилцох ажлыг эхлүүлэх, эхний ээлжинд экспортын гаалийн мэдүүлэгт RDF-ээр хавсаргасан бичиг баримтыг гаалийн байгууллагаас УБТЗ ХНН-т цахимаар хүргүүлэх асуудлаар санал солилцсон. Энэ асуудлыг МТГ-т танилцуулж, програмд нэмэлт, хөгжүүлэлт хийлгэх санал хүргүүлнэ.		
4	Хуралд оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	ХБ3-аас зохион байгуулах уулзалтад оролцох	Замын-Үүд боомтын ачааны терминалыг 2024.04.01-ний өдрөөс 2024.09.30-ны өдрийн хооронд 24 цагаар ажиллуулахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан бэлтгэл ажлыг хангахаар ХБ3-аас 2024.03.29-ний өдрийн 10:00 цагаас зохион байгуулсан хуралд оролцсон.	04.01 04.01	100
5	Хуралд оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	УБТЗ ХНН-ээс зохион байгуулах уулзалтад оролцох	УБТЗ ХНН-ээс 2024.03.29-ний өдрийн 13:00 цагаас Хамтын ажиллагаа 2024 сэдвээр зохион байгуулагдсан хуралд оролцсон.	03.29 03.29	100
6	Хуралд оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	ҮҮХҮЯ-д зохион байгуулагдах хуралд оролцох	Биржийн худалдаатай холбоотой асуудлаар ААН-д тулгарч байгаа асуудлын талаар ҮҮХҮЯ дээр 2024.04.05-ны өдөр зохион байгуулагдсан хуралд оролцсон. ЭТТ, Энержигээс дотоодын гэрээгээр худалдаж авсан шаардлага хангахгүй нүүрсийг баяжуулан өөрсдөө экспортлох хүсэлт гаргасан ААН-ийн асуудлыг ажлын хэсэг гаргаж ажиллуулан шийдвэрлүүлэхээр тохирсон.	04.05 04.05	100
7	Санал солилцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Эрээнцавын зураг төслийн компанийтай хийх уулзалтад оролцох	Эрээнцавын зураг төслийн компанийтай 2024.04.08-ны өдрийн 14:00 цагт санал солилцсон.	04.08 04.08	100
8	Цахим уулзалтад оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	ESCAP, WCO-ээс цахимаар зохион байгуулах төмөр замын тээвэртэй холбоотой уулзалтад оролцох	ESCAP, WCO-ээс 2024.04.11-ний өдрийн 15:00 цагт цахимаар зохион байгуулсан төмөр замын тээвэртэй холбоотой уулзалтад ГУБ Д.Ням-Осор, МТГ-ын ГУАБ Н.Мөнхзүл нарын хамт оролцсон. Уулзалтаар төмөр замын транзит тээврийг үр дүнтэй болгох, хил дамнасан цахим мэдээлэл солилцоог дэмжих төслийн зүгээс Монгол Улсын талд Бизнес процесс анализ хийх чадавхийг бэхжүүлэх чиглэлээр 2024 оны 12 дугаар сар хүртэл төсөл хэрэгжүүлэхээр болсон. Тус төслийн ажлын даалгаврыг манайх	04.11 04.11	100

					руу имэйлээр явуулж, санал авах, мөн Монгол талын зөвлөх авахаар тохирлоо.		
9	Хуралд оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	УУХҮЯ-ны ТНБД-ын 2024.04.09-ний өдрийн А/37 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах	УУХҮЯ-ны ТНБД-ын 2024.04.09-ний өдрийн А/37 дугаартай тушаалаар байгуулагдсан уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, холбогдох Засгийн газрын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах ажлын хэсгийн 2024.04.18-ны өдрийн 12:00 цагт УУХҮЯ зохион байгуулагдсан хуралд оролцсон.	04.09 04.09	100
10	ЧХОУНБГГ-ын үйл ажиллагааг танилцуулах	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	ГЕГ-ын даргин 2024.04.10-ны өдөр баталсан хөтөлбөрийн дагуу ажиллах.	ГЕГ-ын даргин 2024.04.10-ны өдөр баталсан хөтөлбөрийн дагуу НҮБ-ын чингэлэг хяналтын хөтөлбөрийг Монгол Улсад хэрэгжүүлэх судалгааны багийн ажилтан Tomas Dixon, Hugo Bartoly нарт ГУБ Э.Одбаяр нарын хамт ЧХОУНБГГ дахь гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагааг 2024.04.12-ны өдөр танилцуулсан.	04.12 04.12	100
11	Ажлын хэсэгт ажиллах	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	УУХҮЯ-ны ТНБД-ын 2024.04.09-ний өдрийн А/37 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах	УУХҮЯ-ны ТНБД-ын 2024.04.09-ний өдрийн А/37 дугаартай тушаалаар байгуулагдсан Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, холбогдох засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах ажлын хэсэгт ажилласан.	04.09 11.30	100
12	Уулзалтад оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	"Хилийн үр ашгийг нэмэгдүүлэх тогтвортой худалдаа төсөл" MON-55044-ийн багаас 2024.05.06-ны өдрийн 09:00 цагт БСҮХ-ны байранд зохион байгуулагдах СЯ, АХБ-ны ажилтануттай хамтарсан уулзалтад оролцсон.	"Хилийн үр ашгийг нэмэгдүүлэх тогтвортой худалдаа төсөл" MON-55044-ийн багаас 2024.05.06-ны өдрийн 09:00 цагт БСҮХ-ны байранд зохион байгуулагдах СЯ, АХБ-ны ажилтануттай хамтарсан уулзалтад оролцсон.	05.06 05.06	100
13	Уулзалтад оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	УБТЗ ХНН-тэй хамтран зохион байгуулах уулзалтад оролцох	УБТЗ ХНН болон ГЕГ-ын дэд дарга Г.Энхтайван, ТОГ-ын дарга С.Баярмаа наратай хамт 2024.05.10-ны өдрийн 10:00 цагт "УБТЗ ХНН болон ГЕГ хоорондын цахим мэдээлэл солилцоо" сэдэвт уулзалтад оролцож, төмөр замаар тээвэрлэгдэж байгаа ачааны тээврийн бичиг баримтыг цахимжуулахтай холбоотой асуудлаар санал солилцсон.	05.10 05.10	100
14	Уулзалтад оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	ХБЗ-аас зохион байгуулсан уулзалтад оролцох	ХБЗ-аас Цагаандэл-Уул Өлзий боомтод ажиллах хилийн хяналтын байгууллагын албан хаагч нарын орон тоо, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний чиглэл, ШНЦ-ын талбайг багасгах,	05.13 05.13	100

15	Ажлын хэсэгт ажиллах	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	ГЕГ-ын даргын 2023.05.05-ны өдрийн А/299 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах.	бүтээн байгуулалттай холбоотой асуудлаар БНХАУ-ын ажлын хэсэгтэй хамтран 2024.05.13-ны өдрийн 14:00 цагаас зохион байгуулсан хуралд оролцсон.	01.01 06.05	100
16	Хэлэлцүүлэгт оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Цахим худалдаанд дэмжлэг үзүүлэх" хэлэлцүүлэгт оролцох.	ЦХХХЯ, ХХЗХ-оос 2024.06.24-нд зохион байгуулсан ГХЯ, ГЕГ, УХШИГГ, Монгол Банк, Шуудангийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжийн төлөөлөл зэрэг 80 гаруй төлөөлөгчид оролцсон "Цахим худалдаанд дэмжлэг үзүүлэх" хэлэлцүүлэгт оролцсон.	06.04 06.04	100
17	Уулзалтад оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	АНУ-ын ЭСЯ-ны дэд атташе Стивен Тимминс, зөвлөх Томас София нартай уулзаж, санал солилцох.	АНУ-ын ЭСЯ-ны дэд атташе Стивен Тимминс, зөвлөх Томас София нартай хакердалт, оюуны өмчийн асуудалтай холбоотой асуудлаар 2024.06.11-ний өдөр ГЕГ-ын 1 дүгээр давхарын хурлын танхимд ГУБ Н.Ойнбилэг, МТГ-ын ГУАБ Н.Мөнхзүүл нарын хамт уулзаж, санал солилцсон.	06.11 06.11	100
18	Ажлын хэсэгт ажиллах	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	ЗТХ-ийн сайдын 2024.07.09-ний өдрийн А/147 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах	ЗТХ-ийн сайдын 2024.07.09-ний өдрийн А/147 дугаартай тушаалаар байгуулагдсан бүх төрлийн шатахуун хадгалах агуулах, буулгах төмөр зам, талбайн хүчин чадал болон төмөр замын тээвэрлэлтийг шуурхай зохион байгуулах арга хэмжээ авах судалгаа хийж, дүгнэлт гаргах ажлын хэсэгт ажилласан.	07.09 11.30	100
19	Хуралд оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	БСҮХ-ын 2024.08.20-ны өдрийн хуралдаанд оролцох.	БСҮХ-ын 2024.08.20-ны өдрийн хуралдаанд ГЕГ-ын даргын хамт оролцсон.	08.20 08.20	100
20	Хуралд оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	--	ЭЗХАБ-ийн бүтээн байгуулалт, гүний гарцын асуудлаар зохион байгуулагдах хуралд оролцох	Замын-Үд Эрээний ЭЗХАБ-ийн бүтээн байгуулалт, гүний гарцын асуудлаар 2024.10.04-ний өдрийн 09:00 цагаас Сонголт дизайн ХХК-ийн байранд зохион байгуулагдах хуралдаанд удирдлагаас өгсөн үүргийн дагуу ХБГ-ын ГУБ М.Батбилэгийн хамт оролцсон.	10.04 10.04	100

21	Хуралд оролцох	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-		ESCAP болон GTI-аас хамтран "Зүүн болон Зүүн хойд Азийн төмөр замын тээвэр, дамжин өнгөрөх ачааны хил дамнасан цахим мэдээллийн солилцоог дэмжих нь" сэдвээр 2024.11.12-ны өдрийн 10:00-18:00 цагт BLUSKY зочид буудлын Кристалл танхимд зохион байгуулсан семинарт оролцож, илтгэл танилцуулсан.	11.12 11.12	100
22	Ажлын хэсэгт ажиллах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	БСҮХ-ны даргын 2024.11.01-ний өдрийн А/84 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах	БСҮХ-ны даргын 2024.11.01-ний өдрийн А/84 дүгээр тушаалаар байгуулагдсан Замын-Үүд, Шивээхүрэн боомтуудын ухаалаг гарцын тоног төхөөрөмжийн үйл ажиллагаатай танилцах, санал дүгнэлт гаргах ажлын хэсэгт ажиллаж байна.	11.01 11.30	100
23	Ярилцлага өгөх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Монгол ТВ-ийн Оргил цаг хөтөлбөрт оролцох	Монгол ТВ-ийн Оргил цаг хөтөлбөрт оролцож, гаалийн хяналт, шалгалтын тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар шууд ярилцлага өгсөн.	11.01 11.01	100
24	Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нарт хичээл заах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Хичээл заах	2024.02.01-ны өдрийн 09:00-12:00 цагт гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхан шатны сургалтад хамрагдаж буй 100 ажилтанд гаалийн хяналт, бүрдүүлэлт, горимтой холбоотой сэдвээр сургалт зохион байгуулсан.	02.01 02.01	100
25	Гаалийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтад оролцогч нарт хичээл заах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Хичээл заах	2024.02.16-ны өдрийн 13:00-16:10 цагт Гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтад оролцогч нарт гаалийн бүрдүүлэлт, хяналт, манифесттай холбоотой сургалт зохион байгуулсан.	02.16 02.16	100

**Гурав. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт		Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
		Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт		
"ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					

1.	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	Сургалтад цахим болон танхимаар оролцсон байна.	ГЕГ-ын даргын 2024.04.22-ны өдрийн А/209 дугаар тушаалаар БНХАУ-ын Худалдааны яамнаас Хөх хотод 2024.04.23-2024.05.02-ны өдрийн хооронд эдийн засгийн хамтын ажиллагаа сэдвээр зохион байгуулсан, сургалтад оролцсон.	04.24 04.25	100
2	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	Сургалтад цахим болон танхимаар оролцсон байна.	Удирдлагын академиас 2024.05.16,17-ны өдрүүдэд "Цахим засаглалын төлөв, цаашдын чиг хандлага" сэдвээр зохион байгуулсан 16 цагийн төлөвлөгөөт кибер аюулгүй байдлын сургалтад оролцсон.	05.16 05.17	100
3	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	Сургалтад цахим болон танхимаар оролцсон байна.	Монголын олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн ажлын албанаас 2024.08.28-ны өдрийн 09:00-17:00 цагт Корпорэйт зочид буудлын хурлын танхимд "Олборлох салбарт авлигатай тэмцэхэд ОҮИТБС-ын стандартыг ашиглах нь" сэдвээр зохион байгуулагдах модуль 1 сургалтад хамрагдсан.	08.28 08.28	100
4	Гадаад хэлний гаалийн хэргийн мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор англи хэлийг бие даан суралцах.	Гаалийн хэргийн англи хэлний мэдлэг дээшилж, "Glossary of international trade and customs terms"-ыг судалсан байна.	Гаалийн хэргийн англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор "Glossary of international trade and customs terms"-ыг судалж байна.	01.02 06.05	100

ТАЙЛАН ГАРГАСАН:  
**ХЯНАЛТ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН ГААЛИЙН**  
**УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ ..... /Ц.ЦЭВЭЭНДАРЬ/ 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР.**



ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Ц.ЦЭВЭЭНДАРИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН  
ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар  
Нэгжийн нэр: Хяналт, бүрдүүлэлтийн газар

**1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
<b>Зорилт 1. “Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт</b>					
1	Гадаад худалдааны цахим нэг цонхны системийг бий болгох	50	5	55	
2	Автозамын хилийн боомтуудын хилээр нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, дэд бүтцийг өргөтгэн шинэчлэх	52	6	58	
3	Автозамын хилийн боомтод суурилуулсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг ашиглан хил хамгаалах байгууллагатай хамтран ажиллаж, хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг нэгтгэнэ	50	5	55	
4	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх	50	5	55	
5	IRU олон улсын байгууллага болон Монголын авто тээвэрчдын нэгдсэн холбоо (НАРТАМ) –той хамтран TIR-EPD, e-TIR системүүдтэй мэдээллийг цахимаар солилцох	55	8	63	
6	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	50	5	55	

7	Үүрэг даалгаврын хэрэгжилтийн биелэлт	55	8	63	
8	Ажлын цаг ашиглалт.	55	8	63	

**Зорилт 4: "Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх"**

9	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	55	8	63	
---	---	----	---	----	--

**Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт**

1	Танилцуулга бэлтгэх	60	10	70	
2	Хуралд оролцох	60	10	70	
3	Уулзалтад оролцох	60	10	70	
4	Хуралд оролцох	60	10	70	
5	Хуралд оролцох	60	10	70	
6	Хуралд оролцох	60	10	70	
7	Санал солилцох	60	10	70	
8	Цахим уулзалтад оролцох	60	10	70	
9	Хуралд оролцох	60	10	70	
10	ЧХОУНБГГ-ын үйл ажиллагааг танилцуулах	60	10	70	
11	Ажлын хэсэгт ажиллах	60	10	70	
12	Уулзалтад оролцох	60	10	70	
13	Уулзалтад оролцох	60	10	70	
14	Уулзалтад оролцох	60	10	70	
15	Ажлын хэсэгт ажиллах	60	10	70	
16	Хэлэлцүүлэгт оролцох	60	10	70	
17	Уулзалтад оролцох	60	10	70	
18	Ажлын хэсэгт ажиллах	60	10	70	
19	Хуралд оролцох	60	10	70	
20	Хуралд оролцох	60	10	70	
21	Семинарт оролцох	60	10	70	

22	Ажлын хэсэгт ажиллах	60	10	70	
23	Ярилцлага өгөх	60	10	70	
24	Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нарт хичээл заах	60	10	70	
25	Гаалийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтад оролцогч нарт хичээл заах	60	10	70	

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хуртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
				1
1	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	100	15	
2	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	90	13.5	
3	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	100	15	
4	Гадаад хэлний гаалийн хэргийн мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор англи хэлийг бие даан суралцах.	90	13.5	
<b>Дундаж оноо</b>			<b>14.2</b>	

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)**

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
			1
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	6	
3.	Асуудал шийдвэрлэх	6	
4.	Хариуцлагатай байдал	7	

5.	Ажлын цаг ашиглалт	7	
	Дундаж оноо	6.6	

#### 4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)	
		1	2
1.	Хандлага, ёс зүй		8
2.	Багаар ажиллах		8
3.	Харилцаа		8
	Дундаж оноо		8

#### 5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгаавар (арга хэмжээ)-ын биелэлт)	67
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	14.2
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	6.6
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
	<b>Нийт оноо =</b>  (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ) ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо	95.8

**Үнэлгээ өгсөн:**

**Нэгжийн дарга:**

Хяналт, бүрдүүлэлтийн газрын даргын  
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

..... (Б.Даваасүрэн)

..... (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,  
зөвшөөрсөн:**

**Төрийн жинхэнэ албан хаагч:**  
Гаалийн улсын ахлах байцаагч

..... (Ц.Цэвээндарь)

..... (огноо)

**Үнэлгээг хянасан :**

**Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:**

Дэд даргын албан үүргийг түр  
орлон гүйцэтгэгч

..... (Г.Энхтайван)

2024.12.20 ..... (огноо)

**Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:**

Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын  
ахлах байцаагч

.....

..... (Ө.Тэгшээ)

2024.12.20 ..... (огноо)

**Үнэлгээг баталгаажуулсан:**

**Төсвийн шууд захирагч**

Гаалийн ерөнхий газрын дарга

..... (Р.Отгонжаргал)

..... (огноо)

